



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ИРГЭД ХҮЛЭЭН АВАХ ТӨВ

*Улаанбаатар сонсож байна ...*

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаар иргэдэд лавлагаа, мэдээлэл өгөх, санал асуулга, судалгаа явуулах, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нийслэлээ хөгжүүлэх чиглэлээр гарч байгаа шийдвэрт иргэдийнхээ санал бодлыг тусгах, төр иргэндээ шуурхай үйлчлэх эрхэм зорилготойгоор энэхүү төв байгуулагдсан юм.

“Иргэд хүлээн авах төв” нь бүрэн автоматжсан системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, иргэдийн талархал, санал, хүсэлт, гомдол, мэдэгдэл нэг бүрийг шуурхай хүлээн авч, холбогдох байгууллага, албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн явц, байдалд хяналт тавин ажиллаж байна. Мөн Нийслэлийн “Лавлагаа, мэдээллийн төв” буюу Call center-ийн үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

“Иргэд хүлээн авах төв”-өөс үзүүлж байгаа үйлчилгээний нэр төрлүүд:

1. **1200** тусгай дугаар бүхий “Улаанбаатар сонсож байна – Иргэдийн өргөдөл, гомдол хүлээн авах утас”-ны үйлчилгээ:


(1200 тусгай дугаарын утсанд холбогдож та нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж талархал, санал, хүсэлт, гомдол, мэдэгдэл гаргаж болох бөгөөд өргөдөл, гомдынхоо шийдвэрлэлтийн явцыг сонсох, хяналт тавих үйлчилгээ)



*Та цүрэн болон суурин телефон утаснаас 1 минутанд 200 төгрөгийн тарифаар холбогдож энэхүү үйлчилгээг авах боломжтой.*

2. [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) веб сайт бүхий “Улаанбаатар сонсож байна – Өргөдөл, гомдлын цахим хуудас”-ны үйлчилгээ:

([www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудсанд хандаж та нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж талархал, санал, хүсэлт, гомдол, мэдэгдэл гаргаж болох бөгөөд өргөдөл, гомдлынхоо шийдвэрлэлтийн явцыг цахим хуудаснаас харах, хяналт тавих үйлчилгээ)



Та [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудсанд хандаж “Бүртгүүлэх” цонхонд өөрийн и-мэйл хаягаа оруулж “Бүртгүүлэх” товчийг даргахад таны и-мэйл хаяганд нууц дугаар очих болно. Дараа нь “Нэвтрэх” цонхонд хандаж и-мэйл хаяг болон нууц дугаараа оруулан “Нэвтрэх” товчийг дарсанаар өргөдөл, гомдлын цахим програм хангамжид нэвтэрч энэхүү үйлчилгээг үнэ төлбөргүйгээр авах боломжтой.

\* \* \*

3. **1234** тусгай дугаар бүхий “Улаанбаатар сонсож байна – Лавлагаа, мэдээлэл өгөх утас”-ны үйлчилгээ:

(1234 тусгай дугаарын утсанд холбогдож та нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаарх лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээ)



Та цүрэн болон суурин телефон утаснаас оператор компаниудын тухайн сүлжээн дэх энгийн тарифаар холбогдож энэхүү үйлчилгээг авах боломжтой.

\* \* \*

4. [www.ub1234.mn](http://www.ub1234.mn) веб сайт бүхий “Улаанбаатар сонсож байна – Лавлагаа, мэдээллийн цахим хуудас”-ны үйлчилгээ:

([www.ub1234.mn](http://www.ub1234.mn) цахим хуудсанд хандаж та нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаарх лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээ)



Та [www.ub1234.mn](http://www.ub1234.mn) цахим хуудсанд хандаж энэхүү үйлчилгээг үнэ төлбөргүйгээр авах боломжтой.

\* \* \*

5. “Улаанбаатар сонсож байна – “Иргэд хүлээн авах төв”-д биечлэн хандаж авах” үйлчилгээ:

(Та “Иргэд хүлээн авах төв”-д хүрэлцэн ирж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж талархал, санал, хүсэлт, гомдол, мэдэгдэл гаргах, шийдвэрлэлтийн хариуг авах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний талаарх лавлагаа, мэдээлэл авах, үнэ төлбөргүй WiFi интернет хэрэглэх, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраас олгох барилга байгууламжийн зөвшөөрлүүд авах, сонин хэвлэл, танилцуулгаас мэдээлэл унших боломжтой үйлчилгээ)

*Та “Иргэд хүлээн авах төв”-д биечлэн хандаж автомат машинаас дугаар авч дарааллын дагуу энэхүү үйлчилгээг үнэ төлбөргүйгээр авах боломжтой.*

\* \* \*

6. “Улаанбаатар сонсож байна – Иргэдэд SMS /мессеж/-ээр мэдээлэл түгээх, танилцуулах” үйлчилгээ:

(Нийслэлийн удирдлагаас гаргасан олон нийтээр дагаж мөрдөх онцлог шийдвэрүүдийг иргэдэд танилцуулах, баяр ёслолын үеэр мэндчилгээ илгээх, мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор SMS /мессеж/-ээр мэдээлэл түгээх үйлчилгээ)

*Таны гар утсанд тухайн мэдээлэл SMS /мессеж/ хэлбэрээр илгээгдэнэ.*

\* \* \*

7. “Улаанбаатар сонсож байна – Иргэдээс санал асуулга, судалгааг SMS /мессеж/-ээр хүлээн авах” үйлчилгээ:

(Нийслэлийн удирдлагаас гаргах гэж байгаа шийдвэрийн талаар иргэдийн санал бодлыг сонсох, хүлээгдэж буй үр дүн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор SMS /мессеж/-ээр санал асуулга явуулах, судалгаа авах үйлчилгээ)

*Таны гар утсанд санал асуулгын мэдээлэл SMS /мессеж/ хэлбэрээр илгээгдэх бөгөөд хариу илгээснээр шийдвэр гаргах түвшинд таны санал тусгагдах болно. Өөрөөр хэлбэл та хэсэгхэн ч болов хугацаанд хотын даргын албыг хашиж байна гэсэн үг. Та гар утасныхаа энгийн SMS /мессеж/-ийн тарифаар хариу SMS /мессеж/ илгээж энэхүү үйлчилгээнд хамрагдах боломжтой.*

\* \* \*

8. “Улаанбаатар сонсож байна – Иргэдээс санал асуулга, судалгааг утсаар авах” үйлчилгээ:

(Нийслэлийн удирдлагаас гаргах гэж байгаа болон гаргасан шийдвэрийн талаар иргэдийн санал бодлыг сонсох, хүлээгдэж буй үр дүн, хэрэгцээ шаардлагыг богино хугацаанд тодорхойлох, дэлгэрэнгүй судалгаа авах, олон иргэдийг хамруулах зорилгоор операторийн багийг ажиллуулан утсаар санал асуулга явуулах, судалгаа авах үйлчилгээ)

*Таны гар утсаар операторын баг холбогдож санал асуулгаа харилцан ярилцах хэлбэрээр явуулах бөгөөд энэхүү үйлчилгээнд та үнэ төлбөргүйгээр хамрагдах боломжтой.*

\* \* \*




Иргэд хүлээн авах төв

Иргэд хүлээн авах төв

Иргэд хүлээн авах төв



Бүтцийн схем:




Манай хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Сүхбаатарын талбайн баруун талд байрлах Нийслэлийн төр захиргааны “Хангарьд” ордоны 1 дүгээр давхар

Утас: 70131200  
70141200  
70123470  
Факс: 70123407  
11-327199

Цахим хуудас: [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn)  
[www.ub1200.mn](http://www.ub1200.mn)  
[www.ub1234.mn](http://www.ub1234.mn)



\* \* \* \* \*